

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2018 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Засгийн газраас нэн яаралтай хэлэлцүүлэхээр 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан "Монголбанк, арилжааны банканд худалдсан биет болон биет бус алтны нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү" гэсэн заалтын хэрэгжих хугацаа 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр дуусгавар болж байгааг дахин 5 жилээр сунгах болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хамрах хүрээг өргөтгөх чиглэлээр холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслүүдийг боловсруулжээ.

Хуулийн төслүүдийг баталснаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй хувь хүн, бичил уурхай, баяжуулах, боловсруулах үйлдвэр эрхлэгчдийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт хамруулах, Монголбанканд тушааж байгаа алтны хэмжээг бууруулахгүй байх, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэх, татварын суурийг өргөжүүлэх боломж бүрдэнэ гэж Засгийн газар үзжээ.

Хуулийн төслүүдийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва 2,5 хувийг 5 хувь болгоход татвараа авч чадахгүй болчихно гэсэн баталгаа байгаа эсэхийг тодорхой болгох, хуулийн төслийн 47 дугаар зүйлтэй холбогдсон өөрчлөлтүүдийг сайтар нягтлах, түүнчлэн гарал үүслийн сертификат болон оюу толгойтой холбоотой асуудал, металлын баяжмалаар гарч байгаа алтны тоо хэмжээг тооцсон хуулийн төслийг Засгийн газар оруулж ирэх, ажлын хэсэг байгуулж сайтар ярилцах, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун алтныхны лобби төрд нөлөөлж байгааг анхаарах, алтны тушаалт нэмэгдэж байгаа нь зөвхөн ганц татвартай холбоотой биш, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилт нөлөөлсөн, манайх дэлхийд битгий хэл хөрш орнуудтайгаа харьцуулахад татвар багатайд тооцогддог, ийм учраас татварыг 2,5 хувь биш 5 хувь болгох, мөн алтны асуудал дээр гадаадын хөрөнгө



оруулагч нарыг биш үндэсний үйлдвэрлэгч нараа дэмжих, хугацааг 5 жилээр сунгахыг дэмжих боломжгүй гэсэн саналуудыг хэлж байсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Д.ДАМБА-ОЧИР**